

## **МОНГОЛЫН ТАЕКВОНДОГИЙН ХОЛБООНЫ САХИЛГЫН ДҮРЭМ**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Нэгдүгээр зүйл. Зорилго

- 1.1 Энэхүү дүрмийн зорилго нь Монголын Таеквондогийн Холбооны (цаашид “Холбоо” гэх) ёс зүйн дүрмийг чандлан сахиулах баталгааг хангуулахаар Ёс зүйн хорооны эрх зүйн байдал, ёс зүйн зөрчил гаргасан тухай маргааныг хянан шийдвэрлэх, сахилгын шийтгэл шийтгэл ногдуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2 Уг дүрэм нь Монгол Улсын Үндсэн хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, Дэлхийн Таеквондогийн Холбооны (WT) сахилгын болон маргаан шийдвэрлэх журам, түүнчлэн Холбооны дүрэм, ёс зүйн дүрэм болон энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛ**

**Хоёрдугаар зүйл. Ёс зүйн зөвлөл, бүрэлдэхүүн**

- 2.1 Монголын Таеквондогийн Холбооны Ёс зүйн дүрмийн 2 дугаар зүйлд заасан тамирчин, дасгалжуулагч, шүүгч, багийн ахлагч, багш, мэргэжилтэн, хувь хүн, клуб, салбар холбоо зэрэг хуулийн этгээд (цаашид “дүрэмд хамаарагдах этгээд” гэх)-ийн ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар хэлэлцэж, дүгнэлт гаргах сахилгын хариуцлага хүлээлгэх чиг үүрэг бүхий Ёс зүйн зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) ажиллана.
- 2.2 Зөвлөл нь Холбооны удирдах зөвлөлөөс сонгогдсон 3-аас дээш гишүүнээс бүрдэх орон тооны бус байна.
- 2.3 Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.
- 2.4 Зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх бүрэн эрх удирдах зөвлөлд хадгалагдана.
- 2.5 Зөвлөлийн гишүүдийн олонхи нь оролцсоноор хүчинтэйд тооцогдоно.
- 2.6 Хэлэлцэж байгаа асуудлыг зөвлөлийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 2.7 Зөвлөл нь түүний бүрэн эрхэд хамаарах асуудлаар хурлаар шийдвэрлэж, тогтоол гаргана.
- 2.8 Зөвлөлийн тогтоол нь нийтэд нээлттэй байх ба хуралдааны тэмдэглэл, шалгалтын материал нь байгууллагын нууцад хамаарна.

**Гуравдугаар зүйл. Шүүгчдийн зөвлөл**

- 3.1 Дотоодод зохион байгуулагдах уралдаан тэмцээний үед Ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх этгээдийн гаргасан ёс зүйн зөрчлийг тухайн тэмцээний ерөнхий шүүгч тэр дор нь хянан шийдвэрлэж, сахилгын хариуцлага хүлээлгэнэ.
- 3.2 Тэмцээний үеэр Ерөнхий шүүгчийн шийдвэрт гомдол гаргах эрх хэнд ч байхгүй.
- 3.3 Ерөнхий шүүгч сануулах, тухайн тэмцээнээс хасах, торгох сахилгын шийтгэх ноогдуулах эрхтэй.
- 3.4 Шүүгчдийн зөвлөлийн даргыг сонгох, чөлөөлөх харилцаа нь удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэгдэнэ.

#### **Дөрөвдүгээр зүйл. Зөвлөлийн гишүүний эрх, үүрэг**

- 4.1 Сахилгын хэрэг үүсгэж шалгах
- 4.2 Сахилгын хэрэгт шалгагдаж байгаа этгээдээс тайлбар авна.
- 4.3 Сахилгын хэргийг шалгахад шаардлагатай мэдээ баримтыг холбогдох иргэн, хуулийн этгээдээс гаргуулах, танилцах эрхтэй.
- 4.4 Зөвлөлийн гишүүн тухайн хэрэгт ашиг сонирхлын зөрчилтэй бол тэр тухайгаа мэдэгдэж, хэргийг хүлээн авах, хянан шийдвэрлэх хуралд оролцохоос татгалзах үүрэгтэй.
- 4.5 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон нийгмийн сүлжээгээр Монголын Таеквондогийн холбооны тамирчин, дасгалжуулагч, шүүгч болон Холбооны ажилтны нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээ, мэдээлэл гарсан тохиолдолд эрх ашгийг нь хамгаалах, нэр төр, алдар хүндийг сэргээлгэх асуудлыг өөрийн санаачилгаар удирдах зөвлөлд цаашлаад хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ МАРГААН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА**

#### **Тавдугаар зүйл. Өргөдөл, гомдлыг хүлээн авах**

- 5.1 Ёс зүйн зөрчил гаргасан тухай маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг өргөдөл, гомдлоор эсвэл зөвлөлийн гишүүн болон холбооны эрх бүхий албан тушаалтны санаачилгаар үүсгэн явуулна.
- 5.2 Иргэн, хуулийн этгээд зөвлөлд өргөдөл, гомдлыг холбооны ажлын албанд бичгээр болон амаар гаргаж болох бөгөөд дараах зүйлийг тусгасан байвал зохионо. Үүнд:
  - 5.2.1 Овог, нэр, холбоо барих хаяг, утасны дугаар
  - 5.2.2 Ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэж байгаа тухайн этгээдийн нэр, гаргасан үйлдлийн талаар
  - 5.2.3 Зөвлөлөөр шийдвэрлүүлэхээр тавьж байгаа шаардлага.
- 5.3 Энэхүү дүрмийн 5.2-т заасан шаардлага хангахгүй ч тухайн өргөдөлд дурьдагдсан мэдээлэл холбооны нэр хүндэд ноцтой хор хохирол учруулж болзошгүй гэж үзсэн

тохиолдолд холбооны удирдлагын хүсэлт эсвэл зөвлөлийн гишүүн өөрийн санаачилгаар шалгалт явуулж болно.

5.4 Өргөдөл мэдээлэл нь гэмт хэргийн шинжтэй бол цагдаагийн байгууллагад шилжүүлж, өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.

### **Зургадугаар зүйл. Хянан шийдвэрлэх ажиллагаа**

6.1 Зөвлөлийн дарга өргөдөл, гомдол хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор хурал зарлах ба зөвлөл тухайн маргааныг хянан хэлэлцэж шийдвэр гаргана.

6.2 Хянан шалгах ажиллагааны хугацаа өргөдөл, гомдол хүлээн авснаас хойш 14 хоног байна.

6.3 Хянан шалгах ажиллагааг явуулж байгаа гишүүн нь шаардлагатай мэдээ баримтыг холбогдох иргэн, хуулийн этгээдээс гаргуулан авах, танилцах, холбогдох талуудаас тайлбар авах зэрэг ажиллагаа хийсний үндсэн дээр дүгнэлт гаргаж зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

6.4 Сахилгын хэргийг хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

6.4.1 Сахилгын шийтгэл оногдуулах /сануулах, мөнгөн торгууль, хугацаатай эрхийг түтгэлзүүлэх, гишүүнээс хасах/

6.4.2 Сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох

6.4.3 Харьяаллын дагуу холбогдох баримтыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх.

6.5 Зөвлөл нь шаардлагатай тохиолдолд зарим асуудлыг эцэслэн шийдвэрлүүлэхээр Холбооны удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж болно.

6.6 Зөвлөл нь гаргасан шийдвэрээ өөрчлөх, эсхүл хүчингүй болгож болно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ САХИЛГЫН ШИЙТГЭЛ**

### **Долоодугаар зүйл. Сахилгын шийтгэл**

7.1 Зөвлөл нь Холбооны ёс зүйн дүрэм, Дэлхийн Таеквондогийн холбооны ёс зүйн дүрмийг зөрчсөн этгээдэд зөрчлийн шинж чанар, хэмжээг харгалзах сахилгын шийтгэл ногдуулна. Зөрчлийн шинж чанар, хэмжээг харгалзан энэхүү дүрмийн 7 дугаар зүйлд зааснаас их эсвэл бага шийтгэл ногдуулж болно.

7.2 Ёс зүйн зөрчил гаргаснаас хойш нэг сарын дотор сахилгын шийтгэл ногдуулна.

7.3 Сануулах, тэмцээнд оролцох эрхийг тодорхой хугацаагаар хасах, зэрэглэл бууруулах, эрх бүхий байгууллагад санал тавих, холбооны гишүүнчлэлээс хасах шийтгэлийг үндсэн шийтгэлээр, тэмцээнээс хасах, торгох шийтгэлийг үндсэн болон нэмэгдэл шийтгэлээр хэрэглэнэ.

7.4 Ёс зүйн нэг зөрчилд сахилгын үндсэн шийтгэлийн хэлбэрүүдийг давхардуулан ногдуулж болохгүй.

7.5 Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно.

Тодорхой хугацааны туршид үргэлжлэх сахилгын шийтгэлийн хувьд тухайн сахилгын шийтгэлийн хугацаа дууссанаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно.

### **Наймдугаар зүйл. Сахилгын шийтгэлийн төрөл**

8.1 Тамирчинд дор дурдсан сахилгын шийтгэл ногдуулна.

8.1.1 Сануулах

8.1.2 50.000 төгрөгөөс 500.000 хүртэлх төгрөгөөр торгох

8.1.3 Тэмцээнээс хасах

8.1.4 Гурван сараас гурван жил хүртэлх хугацаанд эрхийг нь хасах

8.2 Дасгалжуулагч, багийн ахлагчид дор дурдсан сахилгын шийтгэл ногдуулна.

8.2.1 Сануулах

8.2.2 100.000 төгрөгөөс 1.000.000 хүртэлх төгрөгөөр торгох

8.2.3 Тэмцээнээс хасах

8.2.4 Гурван сараас гурван жил хүртэлх хугацаанд олон улсын болон дотоодод зохион байгуулагдах тэмцээн, наадамд оролцохыг хориглох

8.2.5 Гурван сараас гурван жил хүртэлх хугацаанд эрхийг нь хасах.

8.3 Шүүгчид дор дурдсан сахилгын шийтгэл ногдуулна.

8.3.1 Сануулах

8.3.2 100.000 төгрөгөөс 1.000.000 хүртэлх төгрөгөөр торгох

8.3.3 Тэмцээнээс хасах

8.3.4 Зэрэглэл бууруулах

8.3.4 Гурван сараас гурван жил хүртэлх хугацаанд олон улсын болон дотоодод зохион байгуулагдах тэмцээн, наадамд оролцохыг хориглох

8.3.5 Олон улсын шүүгчийн жагсаалтаас хасуулах санал гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх.

### **Есдүгээр зүйл. Зөрчлийн төрөл**

9.1 Холбооноос зөвшөөрөл авалгүйгээр хамгийн багадаа гурван клуб, холбоо оролцох таеквондогийн арга хэмжээ, эсвэл тэмцээн зохион байгуулсан, холбоонд өөрсдийн зохион байгуулсан арга хэмжээ, эсвэл тэмцээний үр дүнгийн тухай мэдээллийг илгээгээгүй бол тухайн клуб, холбоог 300.000 – 3.000.000 төгрөгөөр торгоно.

9.2 Тамирчны нэр, нас, жин, ангилалыг буруу мэдээлж тэмцээнд оролцуулсан тухайн клуб, байгууллагыг буруу мэдээлсэн тамирчны тоогоор 200.000 – 2.000.000 төгрөгөөр торгоно.

- 9.3 Зохисгүй байдал гаргасан болон биеэ авч явах зан үйлтэй холбоотой Ёс зүйн дүрэмд заасан хэм хэмжээг зөрчсөн бол тамирчин, дасгалжуулагч, шүүгчийг 3 сараас 3 жил хүртэлх хугацаанд эрхийг нь хасна.
- 9.4 Шүүгчийн шийдвэрийг зүй бус аргаар эсэргүүцэх, эрх бүхий ажилтны шаардлагыг эсэргүүцсэн тамирчин, дасгалжуулагчийг тухайн тэмцээнээс хасах, 100.000 – 1.000.000 төгрөгөөр торгоно.

## **МОНГОЛЫН ТАЕКВОНДОГИЙН ХОЛБОО**